



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/212

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд Хэрлэн суманд хэрэгжих Хэрлэн голын гүүрнээс Ханбүргэдийн уулзвар хүртэлх авто замын засвар, тохижилт, гэрэлтүүлэг, 4-н зам-Хишигийн уулзвар-Хэрлэн зоогийн уулзвар хүртлэх зам, Гэр хорооллын хайрган хучилттай авто замын засварын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	И.Баасанжав	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Э.Элбэг-Эрдэнэ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Х.Гонгор	Иргэний төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ